БАТЛАВ
ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН

"АРВАН МЯНГАН ХҮЛЭМЖ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД
НИЙЛҮҮЛЭХ ХҮЛЭМЖИЙН ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ (БАГЦ-1)

**1.Байршил**: Хэрлэн сумын 11 багт

**2. Нийлүүлэх барааны хэмжээ**: MNS 6636:2016 стандартын шаардлага хангасан иж бүрэн нийт 197 ширхэг хүлэмж нийлүүлнэ. Үүнд:

-4*8 м²-ийн хэмжээтэй /32м²/ зуны нийлэг хальсан бүрхүүлтэй 170 хүлэмж
-6*10 м²-ийн хэмжээтэй /60м²/ зуны нийлэг хальсан бүрхүүлтэй 27 хүлэмж

**3.Ерөнхий шаардлага:**

3.1.Хүлэмж нь нийлэг хальсан бүрхүүлтэй, нуман оройтой, хавар-зун-намар ашиглагдах, төрөл бүрийн хүнсний ногоо, цэцэг, эмийн ургамал, мод үржүүлгийн ажил хийх боломжтой.

3.2.Хүлэмжийн иж бүрдэл нь MNS 6636:2016 стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

3.3.Нийлүүлэх хүлэмж нь импортын материал сонгон худалдан авч буй тохиолдолд тохирлын гэрчилгээ, тухайн улсын стандартад нийцсэн сертифкат, паспортийг хавсаргана.

3.4.Тухайн хүлэмжийг барих зураг тайлбартай байна.

3.5.Ажлыг гүйцэтгэгч байгууллага мэргэжлийн багшаар нь тухайн хүлэмжийг барих, ашиглах, хүнсний ногоо тарих чиглэлээр ашиглагч байгууллагын ногоочид, иргэдэд технологийн сургалтыг зохион байгуулна.

3.6.ХАА-н тоног төхөөрөмж, хүлэмж импортлох чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан мэргэжлийн аж ахуй нэгж, байгууллага, төрийн бус байгууллага байна.

4. Нийлүүлэх хүлэмжийн материал нь доорх техникийн шаардлага хангасан байна. Үүнд:

| № | Материалын нэр | Техникийн шаардлага |
|---|---|---|
| 1 | **Нийлэг хальсан бүрхүүл** | ➢ Нарны гэрэл сайн нэвтрүүлдэг, тунгалаг, дулаан барих чадвартай, усан дусал үүсэхгүй байх,<br>➢ 40-өөс +50 хэмд физик шинж чанараа алддаггүй, 0.10 мм-ээс дээш зузаантай, ашиглалтын хугацаа 2-оос доошгүй жил ашиглах боломжтой.<br>➢ Заагдсан хэмжээтэй нуман нурууг бүрэн хучихад хүрэлцэхүйц хэмжээтэй байна. |

| | | |
|---|---|---|
| 2 | **Нуман нуруу /карказ/** | ➢ Хүлэмжийн:<br>- Өргөн 4 м, урт 8 м, өндөр нь 2.5 м-аас доошгүй байх ба нийт талбай 32 м$^2$,<br>- Өргөн 6 м, урт 10 м, өндөр нь 2.5 м-аас доошгүй байх ба нийт талбай 60 м$^2$ тус тус байна<br>➢ Зэвэрдэггүй цайрдсан гангаар хийсэн их биетэй, 1.5 мм буюу түүнээс дээш зузаан ханатай, диаметр нь 25 мм буюу түүнээс дээш, босоо нуман тулгууруудын хоорондох зай 0.8 метрээс ихгүй, 25 см зузаантай нойтон цас, 25м/сек-ийн хурдтай салхийг тэсвэрлэх чадвартай байх<br>➢ Хучлага болон бусад хийгдсэн материал төхөөрөмжийг даахуйц бат бэх, бүрэн бэхэлгээтэй, даац нь 15 г/м² байх |
| 3 | **Усалгааны төхөөрөмж** | **Усалгааны хоолой:** Ил болон далд хөрсний дуслын усалгааны иж бүрдэл төхөөрөмж,<br>➢ 32 м$^2$ буюу 8м-ийн урт, 4 м-ийн өргөнтэй талбайд 6 эгнээ,<br>➢ 60 м$^2$ буюу 10м-ийн урт, 6 м-ийн өргөнтэй талбайд8 эгнээ дуслын услалтын систем, ус шахах цахилгаан помп, усны механк бохирдол шүүх филтэртэй байх, |
| 4 | **Агааржуулагч** | ➢ **Агааржуулагч:** 32 болон 60 м2 бүхий хүлэмжинд 2 талдаа агааржуулах зориулалтын хийцтэй, түүнийг нээж, хаадаг нээлхий ( хаявч)-тай байх, |
| 5 | **Хаалга** | ➢ 32м2 таблай хүлэмжний хаалганы өргөн 0,9-1,0 м, өндөр 1,9 м-ээс доошгүй байх,<br>➢ 60 м2 талбай хүлэмжний хаалганы өргөн 1,6 м-аас доошгүй, өндөр 1,9 м-ээс доошгүй, өндөр нь 1,9 м-ээс доошгүй, 2 тийш замаар гүйж нээгдэж хаагддаг.<br>➢ Хаалгыг 1,5 мм зузаантай цайрдсан 25*25 мм дөрвөлжин огтлолтой, 25 мм-ийн ган хоолойгоор хийнэ.<br>➢ 32 болон 60 м2 талбайн хүлэмж нь нэг талдаа хаалгатай, нэг хажуу нэг хаяавтай байна. |
| 6 | **Дагалдах багаж, сэлбэг** | ➢ Үйлдвэрлэгчийн стандартын дагуу дагалдах сэлбэг, хүлэмж угсрахад зайлшгүй шаардагдах багаж, даруулга, гадас, температур, агаарын харьцангуй чийг хэмжигч, нарны хэт халалтаас хамгаалах торон хучлага, тарьмал сойлгын зохриулалтын байна.<br>➢ Хөрс сийрүүлэх тармуур, хог ургамал устгах гаапуу, хөрс уллах хүрз зэрэг 3 иж бүртэл багаж, |
| 7 | **Мэргэжлийн багийн шаардлага** | ➢ ХАА-н тоног төхөөрөмж, хүлэмж импортлох чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан мэргэжлийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага байх,<br>➢ Бүрэлдэхүүн:<br>- Хүлэмжийн аж ахуйн чиглэлээр сургалт, зөвлөгөө өгөх магадлан итгэмжлэгдсэн байгууллага, эсвэл зөвлөх мэргэжилтэн байх, |

| | | |
|---|---|---|
| | | - Олон жил төмс, хүнсний ногооны чиглэлээр ажилласан дадлага туршлагатай агрономич мэргэжилтэнтэй байх, гэрээт байгууллага байж болно. |

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.НЯМСҮРЭН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН С.СОЛОНГО

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН:
АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ХҮНС,ХӨДӨӨ АЖ АХУЙ ГАЗРЫН ҮЙЛДВЭР ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА Ч.САМБУУААТАР